



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 1104

Номгон

Г Төрийн Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг мэдээллийн технологит шилжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг мэдээллийн технологит шилжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2 дугаар заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Төрийн Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг мэдээллийн технологит шилжүүлэх үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлж, хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Архивын тасаг (В.Эрдэнэчимэг)-т, дагаж мөрдөж ажиллахыг нийт байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220007

Аймгийн Засаг даргын *О.О.О.* ОНЫ *01* дүгээр сарын  
*06* ны өдрийн *04* дүгээр өрхирэмжийн хавсралт

**“ТӨРИЙН АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МЭДЭЭЛЛИЙН  
 ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ 2022 ОНД  
 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1	2	3	4	5	6	7	8
	<b>А/Д</b>	<b>Үйл ажиллагаа</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Хугацаа</b> а	<b>Хэрэгжилтийг хариуцах байгууллага</b>	<b>Хамтран хэрэгжүүлэх байгууллаг</b> а	<b>Төсөв</b>
<b>Нэг. Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтыг цахим санд оруулахад бэлтгэх, нягтлан шалгах</b>							
1	1.1	Архивын ерөнхий газраар 3 ажилтны цалин санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэн Төрийн архивын баримтыг цахим санд шилжүүлэх	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх, ажилтнуудын төлөвлөгөөний биелэлтээр	Жилдээ	Төрийн архивын тасаг	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв 43.705 сая/төг

Архивын салбарт техникийн шинэчлэл хийх, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг өргөн ашиглах замаар архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг автоматжуулах зорилтыг үе шаттайгаар шийдвэрлэж, төрийн архивын мэдээллээр үйлчлэх боловсронгуй тогтолцоог бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

Төрийн болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн мэдээлэл, эрэл хайлтын үйл ажиллагаа автоматжиж шинэ шатанд гарч, архивыг судлах, сонирхох, олон нийтийн хэрэгцээ өсөн нэмэгдэж мэдээллийг цахим хэлбэрээр ашиглах боломж бий болж архив нээлттэй, хүртээмжтэй байх хуулийн зарчим бүрэн хэрэгжиж баримтыг ашиглалтаас бүрэн чөлөөлж хадгалалт хамгаалалт сайжирна.

1	2	3	4	5	6	7	8
2	1.2	“Төрийн архивын баримтыг Иж бүрэн нягтлан шалгах” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтээр	Жилдээ	Төрийн архивын тасаг	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв
3	1.3	“Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтээр	Жилдээ	Төрийн архивын тасаг	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв

-----oOo-----